



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/45

Баян-Адарга сум

**Газрын дуудлага худалдааг
хүчингүй болгох тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дэх хэсэг Засгийн газрын 2016 оны "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам батлах тухай" 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар 19-ний өдрийн 8 дугаар Хуралдаанаар хэлэлцэн хасагдсан боловч Тогтоол дээр хасалгүй бичсэний улмаас андуурагдаж 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/31 дугаар захирамжаар 5013991 төлөвлөлтийн нэгж талбар бүхий дуудлага худалдаа зарлагдсан байх тул дээрх нэгж талбарын дуудлага худалдааг хүчингүй болгосугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/31 дугаар захирамжийн хавсралтын хоёр дахь хэсгийг хүчингүйд тооцсугай.

3.Захирамжийн хэрэгжүүлж гарсан алдааг залруулж ажиллахыг Газрын даамал (Б.Буянбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ӨЛХАГВАДОРЖ

